



ЯМААН УСНЫ ХАВЦЛЫН ХАНАН ХАДНААС ШИНЭЭР ИЛРҮҮЛСЭН БИЧЭЭСҮҮД

Ноостын БАЯРХҮҮ

Түлхүүр үг. Монгол Алтай, Ховд аймаг, Алтай сум, Ямаан Усны хавцал, Ханан хадны бичээс

Өгүүллийн товч агуулга. Тус өгүүлэлд Ямаан Усны хавцлын Ханан хаднаас шинээр илрүүлэн олсон бичээсүүдийг нягтлан үзэж шинжлэх ухааны эргэлтэд оруулах зорилгоор урьдчилсан байдлаар тайлан уншсанаа нийтлүүлж байна. Мөн өмнө нийтлүүлсэн бичээсийн эхийг дахин нягталж өмнөх судалгаанд гарсан зарим нэг эргэлзээтэй хэсгийг тодруулж шинээр уншсан болно. Бичээсүүд он цагийн хувьд харилцан адилгүй бөгөөд ерөнхийдөө Уйгурын үед холбогдоно хэмээн үзэж байна.

Судалгааны тойм

Монгол Алтайн Нурууны өвөр бис, Ховд аймгийн Алтай сумын нутаг, Ямаан усны хавцалд голын зүүн талаас түрж орсон хушууны баруун хойш харсан 30 орчим метр өндөртэй хадныг Ямаан Усны “Ханан хад” хэмээн нэрлэдэг. Энд олон янзын өгүүлэмж бүхий хадны сүг зураг, руни үсгээр бичсэн бичээсүүд, олон төрлийн тамга тэмдэг бий.

Ямаан Усны Ханан хадны дурсгалыг анх 1973 онд Ховд, Говь-Алтай аймгийн нутагт ажилласан МЗТСХША-ийн үсэг бичиг, хадны зураг судлах багийнхан олж илрүүлсэн бөгөөд тухайн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд явж байсан Э.А.Новгородова шинээр олж илрүүлсэн бичээсийн гар хуулбарыг хийж Оросын түрэг судлаач эрдэмтэн Э.Р.Тенишевт өгснөөр уг бичээсийг тайлан уншиж 1983 онд буюу олж илрүүлснээс хойш арав гаруй жилийн дараа “Новые рунические надписи в горах Монгольского Алтая” нэрээр хэвлүүлж шинжлэх ухааны эргэлтэд оруулсан байна [Тенишев, Новгородова, 1983, 205-208].

Тухайн үед 2 мөр түрэг бичээсийг олж илрүүлэн уншиж судалсан ба үүнээс хойш уг хадны бичээсийг дахин очиж нягтлан шалгасан хүн байхгүй бөгөөд Академич Л.Болд 1990 онд хэвлүүлсэн “БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс”, 1995 онд “Орхон бичгийн дурсгалууд-II”, хожим 2006 онд нэмж засварласан хоёр дахь хэвлэлдээ тус тус “Ханан хадны орхон бичээс” нэртэйгээр хэвлүүлсэн байх ба Э.Р. Тенишев, Э.А.Новгородова нарын хэвлүүлсэн эхийг хэвээр авч оруулжээ [Болд, 1990, 1995, 2006, 245-248].

Үүнээс гадна Ховд Их Сургуулийн багш Б.Батмөнх бүтээлдээ “Ханан хадны түрэг бичээс” хэмээх нэрээр оруулсан боловч бичээсийг биеэр очиж үзэлгүй бичээсийн тодорхойлолт, гар хуулбарын зургийг Э.Р.Тенишев, Э.А.Новгородова нарын хэвлүүлснээс, харин бичээсийн галиг болон орчуулгыг Л.Болд гуайн хэвлүүлсэн эхээс шууд эш татан авсан бололтой [Батмөнх, 2006, 115-116].

Ийнхүү 1973 оноос хойш дахин судлаагүй байсан Ямаан Усны хавцлын Ханан хадны бичээсийг 35 жилийн дараа Монгол Алтай Судлалын Хүрээлэнгээс хэрэгжүүлж буй “Монгол Алтайн баруун хэсгийн түүх археологийн дурсгалууд-II” төслийн хүрээнд Үенч, Алтай, Цэцэг, Мөст сумдын нутагт ажилласан судалгааны II багийнхан зорин очиж дахин нягтлан шалгаснаар өмнөх эрдэмтдийн хоёр мөр бичээс гэж үзэж байсан бичээсээс гадна руни үсгээр бичсэн гурван мөр бичээс буйг шинээр илрүүлэн олсон юм [Төрбат, Баярхүү, Идэрхангай, 2009].

Тус өгүүлэлд шинээр олж илрүүлсэн бичээсүүдийг судалгааны эргэлтэд оруулах, түүнээс гадна өмнө нь олж илрүүлэн уншиж судалсан бичээсийг нягтлан үзэж, дахин унших оролдлого хийсэн болно.

Ханан хадны бичээс

Анх 1973 онд олж илрүүлэн гар хуулбарыг хийсэн Э.А.Новгородовагийн хуулбарт тулгуурлан уншсан Э.Р.Тенишев уг бичээсийг тамганы хоёр талд бичсэн хоёр мөр бичээс гэж тодорхойлон уншиж судалсан байдаг. Тиймээс өнөөг хүртэл Ямаан Усны бичээс гэдэг нь хоёр мөр бичээс байдаг гэж тодорхойлон, дам эш татан бичсээр байсан билээ.

Гэтэл уг бичээс нь хоёр мөр биш гурван мөр бичээс болохыг олж тогтоосон юм. Өөрөөр хэлбэл, 1-р мөр гэж уншиж байсан бичээс нь нэг мөрөнд байгаа мэт харагдаж байгаа боловч үнэндээ хоёр тустаа бичээс гэж үзэх хэд хэдэн шалтгаан байгааг доор дурдъя.

- **Үсгийн хэмжээ.** Үсгийн хэмжээ буюу үсгийн өндөр болон өргөнийг харьцуулан харахад харилцан адилгүй байна. Үүнийг 1-р бичээст гарч буй п (п), 2-р бичээст гарч буй п (п) үсэгтэй харьцуулахад илэрхий харагдана /Зураг 1/. Өмнөх судлаачдын уншсанаар нэгдүгээр мөрийн эхний үгийн үсгүүд нь хэмжээний хувьд том бөгөөд өөр хоорондоо жигд бус /Зураг 2/ байхад дараагийн үгийн үсгүүд нь харьцангуй жижиг хэмжээтэйн дээр ойролцоо өндөртэй, жигд бичигдсэн байна /Зураг 3/.

- **Зурлага.** Үсгийн зурлага мөн харилцан адилгүй байна. Тухайлбал, эхний үгийн бараг бүх үсгийг олон дахин давхарлан зурж бичсэн нь нэлээд мохой үзүүртэй зүйлээр бичсэн боловч уу гэх сэтгэгдэл төрүүлж байна /Зураг 2/. Харин дараагийн буюу хоёрдугаар хэсгийн үгийг бичихдээ хурц үзүүртэй зүйлээр олон дахин давхарлалгүй ердөө ганц зураасаар маш гаргацтай тод бичсэн нь эрс ялгарч харагдаж байна /Зураг 3/.

- **Үг хоорондын зай.** Үг хоорондын зайг төгсгөлийн хэсэгт хоёр цэг буюу богино ташуу зураасаар маш тодорхой гаргаж өгсөн /Зураг 3/ байхад зөвхөн эхний үг нь дараагийн үгнээсээ 10 гаруй см-ийн зайд бичигдсэн.

- **Бичээсийн утга.** Бичээсийн утгаас харахад нэг цогц утга илтгэх боломжгүй, хоёр өөр утгатай байна.

- Дээр дурдсан үндэслэлүүдээс гадна бас нэг гол үндэслэл бол гар хуулбар хийж авахдаа алдаж хуулснаас бичээст огт байхгүй үсэг нэмж улмаар эхний үгийг өөрөөр уншсан байна. Руни бичгийн гол онцлог нь гийгүүлэгчийг дангаар бичсэн тохиолдолд эгшгээр амилуулан уншдаг тул 1-р мөрийн эхний үгэнд огт байхгүй q (н) үсгийг нэмж уншсанаар үг, өгүүлбэрийн утга өөр болжээ /Хүснэгт 1/.

Эдгээр үндэслэлүүдээр нэг мөр бичээс хэмээн уншиж байсан уг бичээсийг салгаж хоёр өөр бичээс хэмээн үзэж байгаа болно.

Иймд тамганы дэргэд буй бичээсийг 1-р бичээс, өмнөх судалгаагаар 2-р мөрийн эхний хэсгийг 2-р бичээс, харин төгсгөлийн хэсгийг нь 3-р бичээс хэмээн шинээр тус тус дугаарласан болно. Доорх хүснэгтэнд бичээсийн эхийг өмнөх судлаачдын нийтлүүлсэн эхтэй харьцуулан үсгийн галиг, үгийн галиг, орчуулгын хамтаар оруулав.

	Э.Р.Тенишев, Э.А.Новгородова нар	Л.Болд	Бид
Гар хуулбар	»» qıḡ : ṣāqıḡ ḥıḡ ḵıḡ ḡḡ	МІД АНХИЙ	ᠬᠢᠷ ᠲᠤᠨᠭᠦᠰ᠋᠎ᠠ
	»» qıḡ : ṣāqıḡ ḥıḡ ḡḡ	»» qıḡ : ṣāqıḡ ḥıḡ ḡḡ	»» qıḡ : ṣāqıḡ ḥıḡ ḡḡ
Үсгийн галиг	1. kün QčWswGz : bn :	GRDm	1. kwnčWR
	2. tmčnTWGRGwRTm		2. RGz: bn: GRDm
Үгийн галиг	1. Kūn q(a)ču sū (a)γ(ī)z, b(ä)n (a)γr(i) d(i)m	1. kūn kāčü sū ayiz bān ayirdim	1. kūnčur
	2. t(ä)m(t)č(i)n tuyr(a) γ urtum	Tāmīčīn tuyray urtim	2. Aryiz: ben: ayīrdīm
Орчуулга	1. Как скроется солище, веди войско я захворал	Нар шингэмэгц цэргээ илгээ. Би (миний бие) өвдлөө.	1. Күнчур
	2. Тем(и)чина ханскому печать я выбил	Тэмичин (хаан) –ы тамгыг сийлсэн би.	2. Аррыз би өвдөв. 3. Тэмичин би тамга сийлэв.

Өмнө өгүүлсэнчлэн бичээсийн 1-р мөрийн эхний хэсэгт гар хуулбараа алдаж хуулснаас хамааран *kün kǎčü sū* гэж уншсанаар өөр утгатай болсон нь хүснэгтээс тодорхой харагдаж байна. Бичээсийн гэрэл зураг болон өөрсдийн хийсэн гар хуулбартай харгуулахад энд *q* (𐰆) болон *sū* (𐰍) гэсэн үсгүүд огт үгүй байна. Тиймээс *kün kǎčü sū* гэж биш *künčur* гэж унших боломжтой бөгөөд энэ нь хүний нэр байна /Зураг 2/.

Мөн дээрх судлаачдын уншснаар *ayiz bān ayirdim* хэмээн уншсан ба *ayiz* (𐰢𐰏)–ийн урд буй *г* (𐰆) үсгийг орхисон байна. Энэ орхигдсон *г* (𐰆) үсэг нь бага зэрэг бүдгэрсэн боловч сайн нягтлан харвал гэрэл зурагнаас ч тодорхой мэдэгдэж байгаа юм. Иймд *ayiz bān ayirdim* гэснийг *Argüz ben ayirdim* гэж уншсан бөгөөд “Аргыз би өвдөв” гэж орчуулах ба Аргыз гэдэг нь мөн хүний нэр болно /Зураг 3/.

3-р мөрийн эхний үгийг өмнөх судлаачид хүний нэр, тэр тусмаа “Тэмичин хааны тамгыг сийлсэн би” гэж орчуулан Тэмүжин гэх нэртэй холбон тайлбарласан нь бий. Энэ хоёр нэр нь үгийн гаралзүйн хувьд нэг гэсэнтэй санал нэгтэй байгаа боловч заавал хаан гэх үг байхгүй байхад тухайн үгийг оруулж хааны тамга гэж үзэх шаардлагагүй юм. Тиймээс “Тэмичин гэх хүн уг тамгыг сийлжээ” гэж ойлгоход болохоор байна /Зураг 4/.

Эдгээрээс гадна 3-р бичээсийн хажууд цохисон тамга нэлээд сонирхолтой байгаа юм. Дээрх судлаачдын нийтлүүлсэн эхийг өөрийн биеэр очиж үзэн харьцуулан харахад тамганы хэлбэрийг арай өөрөөр энгийн дэгээ, гогцоо мэт хэлбэртэй болгон хуулбарласан байв /Зураг 5/. Тамганы хэлбэрийг харахад яг үүнтэй ижил нь Говь-Алтай аймгийн нутгаас олдсон Шаахарын түрэг бичээсийн хажууд цохисон тамга юм /Зураг 6/. Харин энэ тамганы нэг хувилбар болох эсрэг тийш харуулан цохисон нь Булган аймгийн Дашанчилэн сумын нутаг, Арханангийн бичээсний доод хэсэгт цохисон нь бий /Зураг 7/.

Шаахар толгойн бичээс [Баттулга, 2005, 29-32] болон, Арханангийн бичээст гарч буй үг хэллэг, бичлэгийн онцлог зэргээс үндэслэн тамга болон бичээсийг Уйгурын үед холбогдуулан үзсэн байдаг [Баттулга, 2005, 119]. Тиймээс Ханан хадны 1-р бичээсийг уг тамгаар нь мөн Уйгурын үед холбогдуулан үзэх бүрэн боломжтой байна.

Ханан хадны 1, 2, 3-р бичээсээс гадна энэ орчимд дахин гурван мөр бичээс бий. Тэдгээр бичээсүүдийг мөр тус бүрээр нь танилцуулъя.

Ханан хадны 4-р бичээс.

Ханан хадны 4-р бичээс нь 1-р бичээсийн зүүн талд бий. Бичээс нийт урт 17 см, үсгийн дундаж өндөр 3-3,5 см ба 8 үсэгээс бүрдэнэ /Зураг 8/.

Бичээсийн эх:

𐰆𐰏𐰢𐰏𐰢𐰏

Үсгийн галиг:

RLLkbWči

4-р бичээсийн хувьд одоогоор зөвхөн эхийн сийрүүлэг, үсгийн галигийн хамтаар оруулан үлдээв. Учир нь нэгдүгээрт цаг хугацааны хувьд шахамдуу байсан тул, хоёрдугаарт урьдчилсан байдлаар судалгааны хүрээнд оруулахыг урьтал болгосон тул алдаа мадагтай уншиж, тайлбар хийхийг хичээсэнгүй. Иймд цаашид нягтлан үзэх бодолтой байгаа бөгөөд Түрэг бичээс судлагч

эрдэмтэн мэргэд уг бичээсийг уншин судлахад нээлттэй болно.

Ханан хадны 5-р бичээс.

Ханан хадны 5-р бичээс нь 4-р бичээсийн зүүн талд бий. Бичээс нийт урт 15,2 см, үсгийн дундаж өндөр 2,5-3 см ба 10 үсгээс бүрдэнэ /Зураг 9/.

Бичээсийн эх:	»(x)hᠠ ᠠᠶᠢᠨᠪᠢᠳᠤ
Үсгийн галиг:	WLGirkn bt(d)m
Үгийн галиг:	ul(u)γ irkin bit(di)m
Орчуулга:	Том (Их) Иркин бичив.

Энд гарч буй ul(u)γ гэх үг нь том, их гэсэн утгатай үг бөгөөд харин irkin гэдэг нь хүний нэр байна. ul(u)γ irkin гэсэн яг энэ байдлаар Келтигиний бичээсийн нүүрэн талын 37-р мөрд тохиолддог. Тиймээс ul(u)γ irkin гэх энэ хэллэг нь Түрэгийн үед байсан төдийгүй Келтигинд зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээст буй тул Ханан хадны 5-р бичээс нь он цагийн хувьд үүнтэй ойролцоо буюу Түрэг-Уйгурын үед холбогдох бололтой. Мөн Арханангийн бичээст irkin гэж гардаг бөгөөд Түрэг, Уйгурын үед дээд албан тушаалтанд олгодог байсан цол [Баттулга, 2005, 119] гэж үзсэн байдаг.

Ханан хадны 6-р бичээс.

Ханан хадны 6-р бичээс нь 5-р бичээсний зүүн талд бий. Бичээс нийт урт 40 см, үсгийн дундаж өндөр 2,5-3,5 см ба 17 үсгээс бүрдэнэ /Зураг 10/.

Бичээсийн эх:	ᠶᠠᠮ ᠤᠯᠤᠰ ᠶᠤᠯᠤᠰ ᠶᠤᠯᠤᠰ ᠶᠤᠯᠤᠰ ᠶᠤᠯᠤᠰ
Үсгийн галиг:	Tm lG yWL tgrm kwē brj
Үгийн галиг:	1. atam eliy yol tägrim küč berin 2. atim eliy yol tägrim küč berin
Орчуулга:	1. Эцэг минь Элиг, хувь заяаны Тэнгэр минь хүч хайрла. 2. Нэр минь Элиг билээ. Хувь заяаны тэнгэр минь хүч хайрла.

Бичээст гарч буй эхний үгийг хоёр хувилбараар уншиж болохоор байгаа ба Элиг гэдэг нь хүний нэр бололтой. Энд 1-р хувилбараар уншихад эцгийнх нь нэр Элиг, 2-р хувилбараар уншивал өөрийн минь нэр Элиг гэж унших боломжтой юм. Энэ бичээст гарч буй сонирхолтой хэллэг нь yol tägrī гэх холбоо үг юм. Энэ нь Thiśastvustik-ийн II хэсгийн 72-р мөрөнд мөн гардаг ба оросоор “бог судьбы” [Древнетюркский словарь, 1969, 271], монголоор “Хувь заяаны (Заяач) тэнгэр” гэх үг юм.

Тиймээс энэ бичээст Эркин гэх эцэгтэй, эсвэл Эркин гэх нэртэй хүн өөрийн хувь заяаны тэнгэр буюу заяач тэнгэрээсээ хүч хайрла хэмээн гуйж бичсэн бичээс ажээ.

Заяач тэнгэр буюу yol tägrī гэх энэ хэллэг нь Timśastvustik-ийн II хэсгийн 72-р мөрөнд гарч буй тул энэ бичээсийн хувьд үүнтэй нэг цаг үед буюу Уйгурын үед холбогдох бололтой.

Ямаан Усны хавцлын Ханан хадны I, II, III болон V, VI бичээст бүгдэд нь хүний нэр байгаа нь сонирхолтой юм. Урд өмнө нь нэг газраас олдож буй хэд хэдэн бичээст бүгдэд нь хүний нэр гарч байсан тохиолдол тэр бүр үгүй билээ. Энд мөр бүрт өөр өөр хүний нэр гарч буйг үндэслэн доорх тайлбарыг хийж болохоор байна. Үүнд:

1. Мөр тус бүрийг өөр хүн бичсэн
2. Бүгд өөр өөр угга илтгэсэн
3. Он цагийн хувьд харилцан адилгүй зэргийг дурдаж болно.

SUMMARY

NEWLY DISCOVERED INSCRIPTION FOR KHANAN KHAD OF YAMAAN US GORGE

Pre-deciphering of some inscriptions, discovered from the Khanan Khad, in the cliff of Yamayan Usun, has been reviewed and is being published in order to inaugurate them to the science. Also the author has reviewed the origin of the inscription and deciphered it again and made clear some doubtful parts in it. All the inscriptions are accounted for dating to different times in each but Yughur in general.

Ном зүй

Древнетюркский словарь, Ленинград, 1969, 269.

Баттулга, 2005, 119

Ц.Баттулга. Монголын руни бичгийн бага дурсгалууд. Улаанбаатар, 2005, 119.

Баттулга, 2005, 29-32

Ц.Баттулга. Шаахар толгойн эртний бичгийн дурсгал. Улаанбаатар, 2005, Боть XXV(248), 29-32.

Болд, 1990

Л.Болд. БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. Улаанбаатар, 1990.

Болд, 2006

Л.Болд. Орхон бичгийн дурсгал-II. Улаанбаатар, 2006.

Тенишев, Новгородова, 1983

Э.Р.Тенишев, Э.А.Новгородова, Новые рунические надписи в горах Монгольского Алтая, -История и Культура, Москва, 1983.

Батмөнх, 2008

Б.Батмөнх. Монгол Алтайн нурууны төв хэсгийн археологийн дурсгалууд. Улаанбаатар, 2008.


Төрбат, Баярхүү, Идэрхангай, 2009

Ц.Төрбат, Н.Баярхүү, Т.Идэрхангай. Монгол Алтайн баруун хэсгийн түүх
археологийн дурсгалууд-II төслийн хээрийн шинжилгээний
тайлан, II хэсэг. Улаанбаатар, 2009. Монгол Алтай Судлалын
Хүрээлэнгийн гар бичмэлийн сан.




1-р бичээсийн n (H) үсэг

2-р бичээсийн n (H) үсэг




Зураг 1.




Зураг 2. Ханийн хадны 2-р бичээс




Зураг 3. Ханан хадны 3-р бичээс



Зураг 5. Э.Р.Тенишев, Э.А.Новгородова
нарын нийтлүүлсэн эх






Зураг 8. Ханан хадны 4-р бичээс



Зураг 9. Ханан хадны 5-р бичээс



Зураг 10. Ханан хадны 6-р бичээс